NorthShore University HealthSystem | Swedish Hospital, Part of NorthShore | nch Northwest Community Healthcare, Part of NorthShore

Гэнэтийн эмнэлгийн төлбөрийн эсрэг таны эрх, хамгаалалт

Таны харьяалагддаг эмнэлгийн байгууллага эсвэл амбулаторийн мэс заслын төвөөс өөрийн харьяаны биш эмчээс яаралтай тусламж авах эсвэл эмчлүүлбэл та үлдэгдэл тооцоо төлөхгүй байх
эрхтэй. Эдгээр тохиолдолд та өөрийн даатгалын нэмэлт төлбөр, хамтын төлбөр

"Үлдэгдэл тооцоо" (заримдаа "гэнэтийн тооцоо" гэж нэрлэдэг) гэж юу вэ?

Та эмч эсвэл бусад эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгчид үзүүлсний дараа нэмэлт төлбөр, хамтын төлбөр ба/эсвэл хасагдах зардал зэрэг зарим таны халааснаас гарах төлбөрийг төлөх шаардлагатай болж болзошгүй. Хэрэв та өөрийн харьяа бус буюу таны эрүүл мэндийн даатгалд харьяалагддаггүй эмч болон эрүүл мэндийн байгууллагад үзүүлэх юм бол гарах нэмэлт зардал эсвэл төлбөрийг бүхэлд нь төлөх шаардлагатай болно.

"Харьяа бус" гэдэг нь таны эрүүл мэндийн даатгалд үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулаагүй эмч, эрүүл мэндийн байгууллагыг хэлнэ. Харьяа бус эмч болон эмнэлэг нь таны даатгалаас төлөх төлбөр ба үйлчилгээний нийт төлбөрийн зөрүүг төлөхийг танд зөвшөөрч болно. Үүнийг **"Үлдэгдэл тооцоо"** гэж нэрлэдэг. Энэ дүн нь таны харьяа эмнэлгийн зардлаас их байх магадлалтай бөгөөд таны даатгалын хасагдах төлбөр эсвэл таны халааснаас гарах төлбөрийн жилийн нормд тооцогдохгүй байж магадгүй юм.

"Гэнэтийн төлбөр" гэдэг нь гэнэтийн үлдэгдэл тооцоо юм. Энэ нь танд яаралтай тусламж үзүүлэх үед, эсвэл харьяа эмнэлэгтээ очих хуваарь гаргасан ч санамсаргүйгээр харьяа бус эмчид үзүүлэх зэрэг таны тусламж үйлчилгээнд хэн оролцож байгааг хянах боломжгүй үед тохиолдож болно. Гэнэтийн эмнэлгийн төлбөр нь процедур эсвэл үйлчилгээнээс хамаарч хэдэн мянган долларын үнэтэй байж болно.

Та дараах тохиолдолд үлдэгдэл тооцоо төлөхгүй байх эрхтэй:

Яаралтай тусламжийн үйлчилгээ

Хэрэв та харьяа бус эмч эсвэл эмнэлгийн байгууллагаас үйлчилгээ мөн яаралтай тусламж авбал тэд таны даатгалаас тогтоосон зардал хуваасан дүн буюу нэмэлт төлбөр, хамтын төлбөр болон хасагдах зардал гэх мэт төлбөрийг танаас авах боломжтой. Та үлдэгдэл тооцоог дараах яаралтай тусламжийн үйлчилгээнд төлөхгүй байх эрхтэй. Үүнд, үлдэгдэл тооцоог төлөхгүй байх эрхээс татгалзсан гэсэн бичгэн зөвшөөрөл өгөөгүй тохиолдолд таны эрүүл мэндийн байдал сайжирч эхэлсний дараах үйлчилгээг биеэ сайжирч эхэлсэн үед авах боломжтой.

Харьяа эмнэлэг эсвэл мэс заслын амбулаторийн төвд үзүүлдэг зарим үйлчилгээ

Харьяа эмнэлэг эсвэл мэс заслын амбулаторийн төвөөс үйлчилгээ авах үед зарим эмч таны даатгалд харьяа бус байх боломжтой. Энэ тохиолдолд тухайн эмч нар танаар

даатгалаас тань тогтоосон зардал хуваасан дүнг төлүүлэх боломжтой. Эдгээр нь яаралтай тусламжийн эм, мэдээ алдуулагч, эмгэг судлал, дүрс оношилгоо, лаборатори, нярайн үзлэг, туслах мэс засалч, эмч, эсвэл эрчимт эмчилгээний үйлчилгээнд хамаарна. Эдгээр эмч нар танаар үлдэгдэл тооцоо төлүүлэх боломжгүй бөгөөд үлдэгдэл тооцоо төлөхгүй байх эрхээсээ татгалзахыг шаардахгүй.

Үлдэгдэл тооцоог төлөхгүй байх эрхээсээ татгалзсан гэсэн бичгэн зөвшөөрөл өгөөгүй тохиолдолд
таныг харьяа эмнэлгээсээ бусад төрлийн үйлчилгээ авахад харьяа бус эмч нар үлдэгдэл тооцоог таниар төлүүлэх боломжгүй.

<u>Хэзээ ч үлдэгдэл тооцоог төлөхгүй байх эрхээс тань таныг татгалзахыг шаардахгүй.</u> Мөн таныг харьяа бус эмнэлгээс үйлчилгээ авахыг шаардаагүй болно. Та эмч эсвэл эмнэлгийн байгууллагаа өөрийн даатгалд тохируулан сонгох боломжтой.

<u>Үлдэгдэл тооцоог хийхийг зөвшөөрөөгүй тохиолдолд танд мөн дараах эрх бий:</u>

- Та зөвхөн өөрт ногдож байгаа төлбөрийг төлөх үүрэгтэй (нэмэлт төлбөр, хамтын төлбөр ба хасагдах зардал зэрэг харьяа эмч, эмнэлгийн байгууллагад үзүүлэхэд төлөх төлбөр). Эрүүл мэндийн даатгал тань таны харьяа бус эмч, эмнэлгийн байгууллагуудад нэмэлт зардлыг шууд төлөх болно.
- Ерөнхийдөө таны эрүүл мэндийн даатгалд дараах зүйлс багтана:
    - Танаас урьдчилан зөвшөөрөл авалгүйгээр яаралтай тусламжийн үйлчилгээний зардлыг төлнө.
    - Харьяа бус эмчийн үзүүлсэн яаралтай тусламж үйлчилгээний зардлыг төлнө.
    - Харьяа эмч эсвэл эмнэлгийн байгууллагад төлөх төлбөрийн хэмжээг тань үндэслэн хэчнээн хэмжээний төлбөр төлөх ёстойг харуулна.
    - Яаралтай тусламжийн үйлчилгээ эсвэл харьяа бус эмнэлэгт үзүүлсэн бол таны хасагдах зардал ба халааснаас гарах төлбөрийн хэмжээг тооцоолно.

Хэрэв танд төлбөр эсвэл төлбөрийн үлдэгдэлтэй холбоотой асуулт байвал дараах дугаарт холбогдоорой:

Нортшор болон Шведийн эмнэлэг	847-570-5000
Нортвестын эрүүл мэндийн тусламж үйлчилгээ	847-618-4780

Хэрэв төлбөр тооцоог тань буруу бодсон эсвэл мэдээлэл авах, гомдол мэдүүлэх бол 1-800-985- 3059 дугаарт холбогдоорой.

Холбооны хуулийн дагуу олгогдсон эрхийнхээ талаарх дэлгэрэнгүй мэдээллийг www.cms.gov/nosurprises/consumers сайтаас авна уу.